

## МОНГОЛ УЛС ТҮВДТЭЙ ЭСЯ-НЫ ХЭМЖЭЭНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ГЭСЭН ОРОЛДЛОГО

*Д. Уламбаяр\**

Олноо өргөдсөн Монгол улс байгуулагдсан цагаасаа өөрийн бүрэн эрх тусгаар тогтнолоо гадаад улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх талаар нэн идэвхитэй үйл ажиллагаа явуулж байсан нь түүхийн баримт бичгүүдэд хадгалагдан үлдсэн билээ. Тухайн цаг үеийн олон улсын нөхцөл байдал, манжийн дарлалаас ангижран эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн, бие даасан засаг төрөө дөнгөж тогтоож байсан Монгол улсын хүчин чадал мөхөдсөний улмаас Богдын засгийн газрын дипломат үйл ажиллагаа төдийлөн амжилтанд хүрч чадаагүй боловч тавьж байсан зорилго алсын хараатай, бодлогын цар хүрээ харьцангуй өргөн байсныг хэн ч үгүйсгэх аргагүй юм. АНУ, Япон, Европын орнуудтай хэлхээ холбоо тогтоох оролдлогууд, Богдын захидал бичгүүд үүний тодорхой нотолгоо юм.

Монгол улсын шашин төрийг хослон барьж байсан Богд гэгээний Засгийн газрын дипломатын талаар олсон амжилтын нэг нь Түвдтэй байгуулсан 1913 оны Гэрээ бичиг билээ. Есөн зүйл бүхий Гэрээний оршил хэсэгт: “Монгол, Түвд тус бүр Манж-Хятадын эрх мэдлээс ангижран тусгаар байгуулсан бөгөөд язгуураас шашин шүтлэгийн хэлхээ холбоо нэгэн болох учраа, үүнээс хоёр улс харилцан бие биедээ тус бололцох тухайг өөр өөрийн Засгийн газрын заавраар Найрамдлын Гэрээ хэлэлцэх тухай Богд хааны зарлигаар томилогдсон Гадаад яамны хамаарсан сайд, нягт билэгт, да лам Равдан (энэ үед ГЯЯ-ны тэргүүн сайд, Чин ван Ж.Ханддорж Санкт-Петербуркт айлчилж байсан юм), эрхэлсэн түшмэл Манлайбаатар бэйс Дамдинсүрэн, Түвдийн хаан Далай ламын зарлигаар томилогдсон гүжир Цанчив ханчин Луузаннаваан, донир Агваанёнзун, мөнгөн санхүүгийн тэргүүлэгч Ишжамц, бичээч Хандгалсан нар хэлэлцэн” тогтжээ. Гэрээний нэгдүгээр зүйлд: “Түвд улсын эзэн Далай ламаас Монгол улсын тусгаар байгуулсныг зөвшөөрөн хүлээнэс гадна, Монгол улсын шарын шашин эзэн Жавзундамба ламыг Монголын хаан болгон өргөмжилснийг басхүү зөвшөөрөн хүлээв” гэжээ. Гэрээний хоёрдугаар зүйлд: “Монгол улсын эзэн Жавзундамба лам Түвдийн тусгаар байгуулсныг зөвшөөрөн хүлээнэс гадна, Түвд улсын хаанд Далай ламыг өргөмжилснийг басхүү зөвшөөрөн хүлээв” гэжээ. Мөнхүү гэрээний бусад зүйлд заахдаа хоёр улс Буддын шашныг хэзээд бадран

\* Д.Уламбаяр - МУИС-ийн ОУХС-ийн докторант

дэлгэрүүлэх, хоёр этгээдэд гадаад, дотоодын харшлах дайсан тохиолдох аваас хэзээд харилцан хамгаалан туслах, харилцан худалдаа нэвтрүүлэх, эд боловсруулах, мөнгө хүүлэх (зээлийн гүйлгээ-Д.У.), хоёр улсаас албан, амин ба шашин шүтлэгийн хэргээр явагчдыг харилцан туслалцахаар тогтжээ.<sup>1</sup>

Монгол-Түвдийн Гэрээний талаар Бээжинд элчин байгаад Хүрээнд томилогдон ирсэн Оросын элчин И.Я.Коростовецаас Петербурт явуулсан яаралтай цахилгаан мэдээнд дурдахдаа: “Аль аль тал нь бүрэн эрх эдлэх хүчин чадал төгс бус тул Монгол, Түвдийн хэлэлцээр нь улс төрийн ач холбогдлыг олж, олон улсын гэрээ бичгийн нэр хүлээж чадахгүй” гэж басамжилсан юм.<sup>2</sup>

Гэвч их гүрнүүд олон улсын харилцааны хэрэг явдлыг ил, далд элдэв аргаар бүхэлд нь шийдвэрлэж байсан тэр хүнд үед бага буурай хоёр улс, ард түмэн бие биеийнхээ тусгаар тогтсоныг харилцан хүлээн зөвшөөрч, найрамдлын барилдлага, харилцан туслалцах гэрээ байгуулж байсан нь бараг ховор бизээ. Үүгээрээ сайхь Гэрээ нь олон улсын харилцаа, дипломатын түүхэнд шинэ зүйл болсон гэж үзвээс зохилтой.

Ер нь Түвд орныг XIX зууны сүүлээс их гүрнүүд сонирхох болсон бөгөөд 1904 онд Англи Лхасыг эрхшээлдээ оруулсны дараа 1907 оны Санкт-Петербургийн гэрээгээр Түвд дэх Английн онцгой ашиг сонирхолыг Хаант Орос хүлээн зөвшөөрсний хариуд Гадаад Монгол дахь Оросын тийм эрхийг Англи зөвшөөрсөн юм.

1913 онд Энэтхэгийн Симла хотноо Түвдийн асуудлаар Англи-Хятадын бага хурал болж энэ үеэр Английн тал Түвдийг гадаад, дотоод хоёр хэсэгт хувааж энд Англи, Хятад хоёр нөлөөний эрх ашгийн хүрээгээ зохицуулах саналыг дэвшүүлсэн боловч Юань Ши-кайн засгийн газар Түвд бол Хятадын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн хэмээн мэдэгдээд хүлээж аваагүй юм. Бага хурал 1914 онд Дели хотноо үргэлжилсэн боловч үр дүнд хүрч чадаагүй ажээ. 1904 онд Лхасыг Английн цэрэг түрэмгийлэхэд XIII Далай лам Хүрээнд дүрвэн ирж Богд хаантай уулзаж энд жил илүү оршин амьдарчээ.

Ардын хувьсгал ялсны дараа ч дээр дурьдсан 1913 оны гэрээ хүчин төгөлдөр хэвээр байсан юм. Тиймээс ч Монгол улсын АЗГ-ын ГЯЯ-наас 1922 оны 3 дугаар сард Түвдийн ГЯЯ-нд явуулсан ноот бичигтээ: “...Түвд, Монгол бидний хоёр улс язгуураас шарын шашны чухал холбогдол бүхий дээр улс төрийн байдал ба засгийн бодлого цөм нэгэн болох бөгөөд өөр өөрийн шашин үндсийг өнө уртад батлан хамгаалах зэрэг хэрэгт зүй нь

ах дүү мэт чадахын чинээгээр харилцан туслалцваас зохих бөлгөө. Манай Богд хаантан ба Ардын Засгийн газар, ард олноор Түвд, Монгол хоёр улс эртнээс Найрамдлын Гэрээ бичиг хэлэлцэн тогтоож, Түвд улсын Засгийн газраас урьдаар манай Монголын Нийслэл Хүрээнд Бүрэн эрх барих төлөөлөгчийг томилон суулгавал элдэв чухал мэдээ нэвтрэлцэж, гадаад лугаа харилцах хэргийг нэгэн мөрөөр явуулан, улс төрийн чухал хэрэг харилцаанд тус хүргэж болох ба бас ч эрхэм улсаас манай Монгол улсын Нийслэл Хүрээ зэрэг газраа шашны ба худалдаа арилжааны хэргээр суугчид цөөнгүй бөгөөд зарим нэг ухвар мөчид хүмүүс манай улсын аливаа хууль дүрмийг шударгаар дагахгүй дахин давтан эсэргүүцэн, өргөдөл бичиг мэдүүлэх зэргийн хэрэг дарцаа гарч ирсэн зүйл буй. Хэрэв эрхэм улсын Засгийн газраас Бүрэн эрх барих төлөөлөгч ирж суух аваас харьяат ардуудад цаг бүр ятган ухуулж, энэ мэтийн хэрэг будлиан өдүүлэхгүй болгон, хоёр улсын зузаан найрамдлыг улмаар бататгаж чадах нь магад хэмээн эрмэлзэн буй тул үүнийг Түвд улсын ГЯЯ-ны эрхэм сайдууд санаа мэдтүгэй хэмээн явуулаад олдвоос эл бүхий байдал учрыг байцаан толилж хэрхэн болгох саналыг илтгэн, даруйханаа хариу ирүүлэхийг гүнээ эрмэлзэнэ”<sup>3</sup> гэжээ. Энэхүү ноотыг ёнзун хамба, номун хан Лувсанхаймчигаар хүргүүлсэн ажээ.

Өгүүлэн буй үед ЗОУ ч Түвдтэй харилцаа тогтоохыг эрмэлзэж байсан юм.

Гэвч тэр үеийн Түвдийн дотоод, гадаад байдал нь Лхасын Засгийн газраас Ардын эрхт Монгол улстай дипломат элчин харилцаа тогтоох тааламжтай нөхцлийг бүрэлдүүлсэнгүй. Учир нь Английн колончлогчдын хэт их нөлөө, Дундад улсын цэргийн халдлага, эзэн хаанаа буулгасан улааны аюул, Монгол ч өөрөө улаан Оросын нөлөөнд автсан зэргээс шалтгаалан Монголын Засгийн газрын санал санаачлагад хариу ирүүлээгүй ажээ.

Тиймээс Улсын Бага Хурал, Ардын Засгийн газар Бүрэн эрхт төлөөлөгчөө шууд томилон явуулж, хэлэлцээ хийх шийдвэрийг 1925 оны 12 дугаар сард гаргаж,<sup>4</sup> төлөөлөгчдийн тэргүүнээр БНМАУ-аас Түвдийн Нийслэл Лхаст суух Бүрэн эрх барих элчин сайдаар хичээнгүй баатар, бэйл Лхасүрэнгийн Гомбо-Идшин, гишүүдэд элчин сайдын зөвлөх Цэвэгдорж (торгууд, орос нэр нь Чавчаев Раш), 1 дүгээр нарийн бичгийн даргаар ГЯЯ-ны түшмэл И.Амгалан, 2 дугаар нарийн бичгийн даргаар М.Бямбаа (халимагийн торгууд, нэр нь Мацак Тоиклевич Бимбаев) болон

бусад хүмүүсийг томилжээ. Төлөөлөгчид Түвдэд очоод харилцаа тогтоож, найрамдлын гэрээ байгуулах, Лхаст Монгол улсын Элчин сайдын яамыг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэх ёстой байв.

Төлөөлөгчид бэлтгэл ажилд нилээд хугацаа зарцуулсны эцэст 1926 оны 9 дүгээр сарын эцсээр Түвд орныг зорьжээ. Зам хол, дотор газар дайн самуун, дээрэм тонуул үлэмж байснаас албан хэрэг, биесийг хамгаалах зорилгоор япон винтов, маузер буугаар зэвсэглэж явжээ. Төлөөлөгчид Улаанбаатараас одоогийн Говь-Алтай аймаг хүртэл автомашинаар, тэндээс цааш гуч гаруй тэмээ, морь хөлөглөн Хятадын Ганьсу мужийг гэтлэн, хөх нуурын Монголд хүрч, улмаар нүүдэллэн явсаар Түвдийн нутагт хүрэлцэн очжээ. Тэднийг буриад голдуу монгол мөргөлчид бараадан хамт явсан ажээ. Энэ тухай И.Амгалангийн замын тэмдэглэл болон ажлын тайланд дэлгэрэнгүй дурдсан байна.<sup>5</sup>

Монголын төлөөлөгчид долоон сар шахам явж 1927 оны 4 дүгээр сарын 28-нд Лхас хотод иржээ. Тэд 8 дугаар сарын 8-нд XIII Далай ламд бараалхаж их хадаг, алт, мөнгөн ембүү, АЗГ-ын ГЯЯ-ны ноот зэргийг өргөн барьж, ирсэн зорилгоо танилцуулж, мөн мөргөл үйлджээ.

Төдөлгүй Түвдийн Засгийн газар албан ёсны төлөөлөгчдөө томилон, хоёр талын яриа хэлэлцээ эхэлсэн байна. Монголын тал “Хоёр улс бие биеэ харилцан бататгах, Бүрэн эрхт төлөөлөгчдөө харилцан суулгах, хоёр улсын иргэд худалдаа наймаа болон хувийн хэргээр зорчиход нь туслалцах, харилцан нэвтрэх бичгийн шууданг байгуулах” зэрэг зургаан зүйлийн санал тавьж хэлэлцүүлжээ. Гэвч Түвдийн тал олон улсын болон дотоодын ээдрээтэй нөхцөл байдлаас шалтгаалан эдгээр саналд даруй хариу өгөхөөс зайлсхийж, багагүй хугацаа өнгөрсөн тул Гомбо-Идшин нар асуудлыг нэгэн тийш болгон шийдвэрлэх, өвлийн ид хүйтнээс өмнө гэдрэг буцахын тулд Түвдийн Гадаад Яамыг яаравчлуулж байжээ. Энэ талаар Түвдийн Гадаад Яаманд явуулсан нэгэн албан бичигт: “Эрхэм улсын Хаан эзэд дээд Богдоос их нигүүлсэнгүйгээр таалан бидний сайд түшмэдийг ирсэн цагаас зүйл зүйлээр өршөөн үзсэн нь ер нь хөнгөн үгүй, бас ч зарлигаар сайд түшмэдийг тусгайлан гаргаж, эл хэргийг удаа дараа хэлэлцүүлж буй нь үнэхээрийн цагийн хэрэг их байдлыг нэвтэрхийлэн толилж, ямагт умард зүгийн шашин амьтны тусыг эрхлэн даалгах ану магад дор гүнээ итгэн биширсээр бөлгөө. Гагцхүү тэр жилийн явуулсан бичгийн хариу эдүгээ хүртэл мэдээ чимээ үгүй дээр, одоо бас бидний бие ирсээр нааш ил далдын

ивээл дор итгэн хүлээсээр өдөр одов. Эл ноёд ихэс ба тухайн хэрэг эрхлэгчид дор учрах шаардах удаа бүр удахгүй сайнаар болно хэмээн урин сайн үгс буй боловч үнэн бүрнийг олж мэдээгүй, харин тухайн ноёд түшмэд тус бүрийг ийн тийн одвой хэмээх зэргээр байн байн элдэв саатал тохиолдон агсаар өчнөөн болов. Бас ч гадна дотно, хол ойрын хач хоч, ил далдын сэжиг таавар үг шүүмжлэлийг үзвээс нэн гоморхолтой зүйл ер нь цөөн үгүй бөгөөд, эдүгээ аваас хүйтэн жихүүний амьсгал орж, бидний улсын газар алсалсан нь нэн маш хол бөглүү, уг газраас олгосон хэрэгсэл зүйл бас ч сар хоногийн тоо тогтоол бүхий агаад одоо дахин давтан хүлээхүйеэ нэн бэрх болсноо” ийнхүү уламжилжээ. Түвдийн Гадаад Яам хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар Монголын талын тавьсан саналуудыг хүлээж аваагүй боловч өөрийн байр суурийг тайлбарласан дэлгэрэнгүй илгээлтийг Монголын төлөөлөгчдөд өгч буцаажээ. Уг илгээлтэд “...хоёр улс дор харилцан албаны хүн суулгая хэмээсэн тухай болваас бусад гадаад улсаас тэр мэт нэгэн адил хүмүүн суулгана хэмээх гэм болохоос аюул тул суулгаж чадахгүй, харин Түвд хоёр улсын найр найрамдал хэмээвээс эртнээс эдүгээ хүртэл шашин шүтлэгийн холбоо улам өглөгийн эзний гүн зузаан найрамдал ер бусад лугаа адилтгаж болшгүй хүнд зузаан нь хэвээр болох бөгөөд тэр ч байтугай Ар, Өвөр Монгол Далай ламаас эхлэн Түвдийн өглөгийн эзэн болсоор ирсэн нь түүх дэвтэр дор тодорхой болой. Ялангуяа эдүгээгийн XIII Далай лам биеэр Монгол газар заларснаас нааш лам шавийн барилдлагаа Түвд, Монголын найрамдал нь маш зузаарсан... Түвд, Монгол хоёр улс найр найрамдлыг эрхлэх ёс дүрэм, аливаа зүйл болваас хоёр этгээд найртай ёсыг тус тусдаа урьд ёсоор барилдаж байваас, тусгаар хүмүүн харилцан суулгана хэмээн ба, харилцан гэрээ бичиг байгуулна хэмээх хэрэг үгүй билээ” гэжээ.<sup>6</sup>

1927 онд хуралдсан Улсын Бага Хуралд ГЯЯ-наас оруулсан илтгэлд: “Түвд улстай найрамдлын холбоог зузаатгах явдлыг цагийн байдалд гүйцэтгэх ба тус улсаас Түвд улсаас одуулсан элчин сайдаас захидал мэдээ аваагүй боловч харъяат яамнаас сонин сэтгүүл бичгийг аяны хүмүүнээр харилцан хүргүүлж хэл авалцаж байх явдлыг арга сүвэгчлэн гүйцэтгүүлж байхыг бодолхийлж буй” хэмээсэн байна.<sup>7</sup>

Монголын төлөөлөгчид Лхаст 5 сар байх хугацаанд XIII Далай ламтай элчин солилцох талаар хэд хэдэн удаа уулзаж ярилцсан боловч эцсийн бүлэгт тэрбээр хэлэхдээ: Нэгд: Түвд

одоогоор ямар ч улстай элчин солилцоогүй, хоёрт: Монголд Хувьсгалт Засаг тогтож бурхан шашнаа унтраасан, гуравт: VIII Богд Жавзундамба таалал төгссөн, ор нь тодроогүй байна. Энэ бүгд хойшид ямар янзтай болохоос шалтгаалж, тэр үед дахин санал солилцож болох юм хэмжээсэнд элчин сайд Л.Гомбо-Идшин бусад хүмүүстэйгээ зөвлөлдөөд 1927 оны 10 дугаар сард нутгийн зүг хөдөлж, олон хоног, сар явсны эцэст 1928 оны 5 дугаар сард Улаанбаатарт иргэж ирсэн байна.

1926 оны Улсын II их хурлын илтгэлд тэмдэглэснээр тус улсад Түвдийн 400 орчим иргэд оршин сууж, 19 пүүс худалдааны үйл ажиллагаа эрхэлж байжээ.<sup>8</sup>

Хэдийгээр Монгол, Түвд хоёр улс олон улсын тавцанд бүрэн хүлээн зөвшөөрөгдөж, бие даан хөгжих боломж, тэр тусмаа элчин сайдын яам байгуулан өргөн хүрээтэй дипломат харилцаа тогтоон хөгжүүлэх бодит нөхцөл бололцоо бүрэлдээгүй байсан боловч шашин шүтлэгийн нягт хэлхээ холбоо, Манжийн эрхшээл, дэлхийн их гүрнүүдийн нөлөөний хүрээнээс ангижрах гэсэн нийтлэг хүсэл зорилгын үүднээс улс хоорондын харилцааны нийтлэг хэм хэмжээг баримтлан бие биеэ дэмжих оролдлогууд хийсэн нь тухайн цаг үедээ томоохон амжилт байлаа. Цаашид энэ талын судалгааг тэр үеийн их гүрнүүдийн хүчний харьцаа, нөлөөний хүрээгээ хуваах харилцан үйлдэл, Монгол, Түвд хоёр орны дотоод, гадаад нөхцөл, ялангуяа Орос, Хятад, Япон, Их Британий дипломат албадын бодлого үйл ажиллагаатай уялдуулан авч үзэхийн зэрэгцээ харилцааг гардан явуулж байсан төр засаг, шашны зүтгэлтнүүдийн үзэл бодол, байр суурийг нухацтай судлах шаардлага хэвээр байна.

### Ишлэл зүүлт

1. УТТА .ФА –4. ХН-658. Б 2. хуулга
2. Известия МИД /1911-1916/ КН. 2 , СПб., 1916, с .51
3. УТТА Ф-1. Т-1. ХН-49
4. Friters G. Outer Mongolia and its international position London ,1951 p. 262
5. Ишдуламын Амгалан /1892-1966/ “Түвдэд зорьчсон замын тэмдэглэл”. “Шинэ толь” сэтгүүл. 1934. УБ., №3-4
6. Мөн тэнд.
7. ГХТА. Ф-4. Т-1. ХН-96
8. БНМАУ-ын Социалист худалдааны түүхэнд холбогдох баримт бичиг. Тэргүүн дэвтэр. (1920-1940). УБ., 1974, 175 дахь тал